

ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР  
СУРГУУЛИЙН 6 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ ХИМИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ  
ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.04

А хувилбар

Хугацаа 40 минут

Анги бүлэг.....

Нэр: .....

1. Тодорхой орон зай эзэлж байгаа масстай биетийг юу гэх вэ? /1 оноо/  
А. Бодис В. Жижиг хэсэг С. Хими Д. Төлөв байдал
2. Усыг халаахад түүнийг бүрдүүлэгч жижиг хэсэг хэрхэн нөлөөлдөг вэ? /1 оноо/  
А. Жижиг хэсгийн хөдөлгөөн хурдан болдог  
В. Жижиг хэсгийн хөдөлгөөн удааширдаг  
С. Жижиг хэсэгт нөлөөлөхгүй  
Д. Зөв хариулт алга
3. Хатуу боловч ямар нэгэн үйлчлэлийн үр дүнд амархан эвдэрч, хэмхэрдэг материалыг ..... гэнэ. /1 оноо/  
А. Зөөлөн В. Хэврэг С.Уян хатан Д. Бат бөх
4. Ямар материал давтагдаж, сунгагддаг, гялалздаг вэ? /1 оноо/  
А. Хэврэг В. Хуванцар С. Металл Д. Металл биш
5. Уусмалд өнгөө өөрчилдөг шинж чанартай бодисыг ..... гэнэ. /1 оноо/  
А. Лакмус В. Индикатор С. Хүчил Д.Суурь
6. Голын усанд хувцас угаах нь усны ямар бохирдлыг үүсгэх вэ? /1 оноо/  
А.Хатуу хог хаягдлын В. Уусдаг хаягдлын  
С. Уусдаггүй хаягдлын Д. Түлшний
7. Багш сурагч А-д бодисын жижиг хэсгийн зураг өгч, тохирох төлөвийг бичих даалгаврыг дараах байдлаар гүйцэтгэсэн бол даалгаврыг гүйцэтгэж зөв хийсэн эсэхийг шалгаж өөрсдийн гүйцэтгэлээ дугуйл. /2 оноо/



Хий



Шингэн



Хатуу

- А. Хатуу, шингэн, хий В. Шингэн, хатуу, хий  
С. Хий, шингэн, хатуу Д. Хатуу, шингэн, хий
8. Шингэн төлөвөөс хатуу төлөвт шилжихэд ямар өөрчлөлт гарч болох вэ? /1 оноо/  
А. Жижиг хэсгүүд сул хүчээр таталцана  
В. Жижиг хэсгүүд хоорондоо таталцахгүй хол байрлана  
С. Жижиг хэсгийн хоорондох таталцах хүч өөрчлөгдөхгүй  
Д. Жижиг хэсгүүд нь хүчтэй таталцан нягт байрлана.
9. Ямар материал сүүдэр үүсгэдэг вэ? /1 оноо/  
А. Тунгалаг В.Тунгалаг бус  
С. Тунгалаг ба тунгалаг бус Д. Аль алинд нь сүүдэр үүснэ
10. Үнэн хариултыг сонгоно уу. /1 оноо/  
А. металлууд нь зөвхөн хатуу төлөвтэй В. металлууд дулаан муу дамжуулдаг  
С. металлууд цахилгаан муу дамжуулдаг Д.металлууд цахилгаан сайн дамжуулдаг

11. Идэмхий бодисын таних тэмдэг аль нь вэ? /1 оноо/



12. Нэгэн хуруу шилтэй өнгөгүй уусмал дээр фенолфталеин индикаторыг дусаахад өнгө нь ягаан болж өөрчлөгдсөн бол уусмал ямар орчинтой байсан бэ? /2 оноо/

- A. Суурилаг      B. Хүчиллэг      C. Саармаг      D. Аль нь ч биш

13. Хэдгэний хатгуураас ялгардаг хор нь бага зэрэг суурилаг байдаг. Түүнд хатгуулсан үед ямар бодисоор саармагжуулах вэ? /1 оноо/

- A. Содын уусмал      B. Шүдний ооны уусмалаар  
C. Цууны хүчлийн сулруулсан уусмалаар      D. Савангийн уусмалаар

14. Суурилаг орчинтой бодис бүхий эгнээг сонго.

- A. Хоолны давс, элсэн чихэр, ус      B. Гарын саван, шүдний оо, хүнсний сод  
C. Хүнсний сод, лимон, хоолны давс      D. Лимон, аарц, кола ундаа

15. Цэгийн оронд тохирох үгийн дугаарыг зөв дараалалд оруулан нөхсөн хариуг сонго.


Хүчиллэг бороо орсноор хөрсний ..... шинж ихэсч, ургамлын өсөлтөд ..... нөлөөлдөг учраас ой модны навч хагдран унаж ..... зогсдог.

Түлхүүр үг : / 1.Өсөлт, 2.Суурилаг, 3.Эергээр, 4.Хүчиллэг, 5.Сөргөөр/

- A. 2-3-1      B. 4-5-1      C. 4-2-1      D. 1-5-4

### Хоёрдугаар хэсэг


2.1 Зургийг сайтар ажиглаад доор өгөгдсөн даалгаврыг гүйцэтгээрэй. /3 оноо/



Эдгээр жижиг хэсгүүдээс тогтож болох материалын жишээ тус бүр 2-ыг бичээрэй.

- X бодис .....  
Y бодис .....  
Z бодис .....

2.2 8-аар тэмдэглэсэн үзэгдлийг нэрлэж энэ үеийн бодисын төлөвийн өөрчлөлтийг жижиг хэсгийн онолоор тайлбарлана уу. /3 оноо/



I. Үзэгдлийн нэр:

.....

II. Үзэгдлийн үе дэх жижиг хэсгүүдийн өөрчлөлтийг жижиг хэсгийн онолоор тайлбарлаарай.


.....  
.....  
.....

III. Тохирох жишээ 2-ыг гаргаарай.....

2.3 Түлхүүр үгийг ашиглан металл биш материалуудын шинжийг ялган бичнэ үү. /3 оноо/  
цахилгаан дамжуулна, цахилгаан дамжуулдаггүй, дулаан сайн дамжуулна, хэврэг, уян хатан, дулаан дамжуулахгүй, давтагдаж сунгагдана, бутрамтгай

.....  
.....

2.4 А ба Б бодисын орчинг тодорхойлж А ба Б бодист тохирох жишээг сонгоорой. /3 оноо/  
Үүнд: Шүдний оо, алим, лимон, хүнсний сод, кола, гарын саван



А.....

.....

Б.....

.....

2.5 Зургийг ажиглан дараах даалгавруудыг гүйцэтгэнэ үү. /3 оноо/  
А. Голын ус юунаас болж бохирдсон бэ? Зургийг ажиглан шалтгааныг тайлбарлаарай.

.....  
.....  
.....

Б. Бохирдсон усны орчин ямар болох вэ? /хүчиллэг, суурилаг, саармаг/

.....

В. Усыг бохирдлоос хамгаалах зөвлөмж бичээрэй.

.....





ДОРНОД АЙМГИЙН ХЭРЛЭН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 12 ДУГААР СУРГУУЛИЙН 6 ДУГААР АНГИЙН СУРАГЧДААС АВАХ ХИМИЙН ХИЧЭЭЛИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ

2024.06.04


Б хувилбар

Хугацаа 40 минут

Анги бүлэг.....

Нэр: .....

1. Хэлбэр дүрсээ хадгалдаг, шахагддаггүй өөрийн гэсэн хэлбэр дүрстэй, масстай бодисыг ямар бодис гэх вэ? /1 оноо/  
A. Хий                      B. Шингэн                      C. Хатуу                      D. Плазм
2. Усыг хөргөхөд түүнийг бүрдүүлэгч жижиг хэсэг хэрхэн нөлөөлдөг вэ? /1 оноо/  
A. Жижиг хэсгийн хөдөлгөөн хурдан болдог  
B. Жижиг хэсгийн хөдөлгөөн удааширдаг  
C. Жижиг хэсэгт нөлөөлөхгүй  
D. Зөв хариулт алга
3. Татаж сунгахад эвдрэлгүйгээр хэлбэр, дүрсээ өөрчилж байвал.....гэнэ. /1 оноо/  
A. Зөөлөн                      B. Хэврэг                      C. Уян хатан                      D. Бат бөх
4. Зэс нь цахилгаан сайн дамжуулдаг материал юм. Энэ нь ямар материал вэ? /1 оноо/  
A. Хэврэг                      B. Зөөлөн                      C. Металл                      D. Металл биш
5. Метилоранж нь суурилаг орчинд ..... өнгө үзүүлдэг. /1 оноо/  
A. Улаан                      B. Ягаан                      C. Өнгөгүй                      D. Шар
6. Голын усанд ахуйн хог хаях нь ямар бохирдлыг үүсгэх вэ? /1 оноо/  
A. Хатуу хог хаягдлын                      B. Уусдаг хаягдлын  
C. Уусдаггүй хаягдлын                      D. Түлшний
7. Зургийн дарааллын дагуу тухайн биет ямар төлөвт оршиж байгааг зөв тодорхойлсон эгнээг олоорой. /2 оноо/



- A. Хий - шингэн – хатуу- хатуу                      B. Шингэн – хатуу – хий – шингэн  
C. Хатуу – шингэн – хий – хатуу                      D. Хатуу – хий – шингэн – хий
8. Хатуу төлөвөөс шингэн төлөвт шилжихэд ямар өөрчлөлт гарч болох вэ?  
A. Жижиг хэсгүүд сул хүчээр таталцана  
B. Жижиг хэсгүүд хоорондоо таталцахгүй хол байрлана  
C. Жижиг хэсгийн хоорондох таталцах хүч өөрчлөгдөхгүй  
D. Жижиг хэсгүүд нь хүчтэй таталцан нягт байрлана.
9. Гэрэл тусгахад түүний нэвтрүүлдэг материалыг сонгоно уу.  
A. Шил                      B. Төмөр                      C. Мод                      D. Цаас
10. Металл бишүүд .....төлөвт оршдог /1 оноо/  
A. Зөвхөн хатуу                      B. хатуу ба шингэн                      C. хатуу, шингэн, хий                      D. шингэн ба хий

11. Тэсрэмтгий бодисын таних тэмдэг аль нь вэ? /1 оноо/



12. Нэгэн хуруу шилтэй өнгөгүй уусмал дээр лакмусын улаан индикаторыг дүрэхэд өнгө нь хөх болж өөрчлөгдсөн бол уусмал ямар орчинтой байсан бэ? /2 оноо/

- A. Суурилаг B. Хүчиллэг C. Саармаг D. Аль нь ч биш

13. Хүний биеийн ходоодны хүчиллэгийн хэмжээ ихэдсэнээс цээж хорсдог. Энэ үед тригель эм нь шинж тэмдгийг бууруулдаг бэлдмэл юм. Тригель эм ямар орчинтой вэ? /1 оноо/

- A. Суурилаг B. Хүчиллэг C. Саармаг D. Аль нь ч биш

14. Хүчиллэг орчинтой бодис бүхий эгнээг сонго.

- A. Хоолны давс, элсэн чихэр, ус  
B. Гарын саван, шүдний оо, хүнсний сод  
C. Хүнсний сод, лимон, хоолны давс  
D. Лимон, аарц, кола ундаа


15. Цэгийн оронд тохирох үгийн дугаарыг зөв дараалалд оруулан нөхсөн хариуг сонго.

Хүчиллэг бороо орсноор хөрсний ..... шинж ихэсч, ургамлын өсөлтөд ..... нөлөөлдөг учраас ой модны навч хагдран унаж ..... зогсдог.

- Түлхүүр үг : / 1.Өсөлт, 2.Суурилаг, 3.Эергээр, 4.Хүчиллэг, 5.Сөргөөр/  
A. 2-3-1 B. 4-5-1 C. 4-2-1 D. 1-5-4

### Хоёрдугаар хэсэг


2.1 Зургийг сайтар ажиглаад доор өгөгдсөн даалгаврыг гүйцэтгээрэй. /3 оноо/



X, Y, Z – ямар бодисын жижиг хэсэг вэ?

X ..... Y ..... Z .....

2.2 С нь бодисын ямар төлөвийг илэрхийлж байна вэ?



I. Төлөвийн нэр: .....

II. С бодисын төлөвийн орчны температурыг бууруулах үед жижиг хэсгийн хөдөлгөөн хэрхэн өөрчлөгдөх вэ? Түүнийг жижиг хэсгийн онолоор тайлбарлан бичнэ үү.

.....  
.....

III. 10 дугаартай үзэгдлийн эсрэг үзэгдлийг нэрлэнэ үү.

.....


**2.3** Түлхүүр үгийг ашиглан металл материалуудын шинжийг ялган бичнэ үү. /3 оноо/

цахилгаан дамжуулна, цахилгаан дамжуулдаггүй, дулаан сайн дамжуулна, хэврэг, уян хатан, дулаан дамжуулахгүй, давтагдаж сунгагдана, бутрамтгай

.....  
.....

**2.4** А ба Б бодисын орчинг тодорхойлж А ба Б бодист тохирох жишээг сонгоорой. /3 оноо/

Үүнд: алимны цуу, аяга угаагч, зуурсан гурил, усан үзэм, цуу, тараг,



А.....

Б.....

.....

**2.5** Зургийг ажиглан дараах даалгавруудыг гүйцэтгэнэ үү. /3 оноо/

А. Голын ус юунаас болж бохирдсон бэ? Зургийг ажиглан шалтгааныг тайлбарлаарай.

.....  
.....  
.....



Б. Бохирдсон усны орчин ямар болох вэ? /хүчиллэг, суурилаг, саармаг/

.....

В. Усыг бохирдлоос хамгаалах зөвлөмж бичээрэй.

.....